

ХОЁР “УХААН”-Ы УУЛЗВАР: ХИЙМЭЛ ОЮУНЫ ХЭРЭГЛЭЭ БА СЭТГҮҮЛЧ МЭРГЭЖЛИЙН ДАСАН ЗОХИЦОЛ

Н.Ариунзаяа*
Б.Баярмаа**
Г.Мэндхүү***

**МУИС, Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны
тэнхимийн дэд профессор, (Ph.D.)*

***МУИС, Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны
тэнхимийн ахлах багш, (Ph.D.)*

****МУИС, Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны
тэнхимийн дэд профессор, (Ph.D.)*

Түлхүүр үгс: хиймэл оюун, GAI, сэтгүүл зүй, мэргэжлийн баталгаажуулалт, ажлын хил хязгаар, ёс зүй, автоматжуулалт

Сэтгүүл зүй нь хиймэл оюуны хөгжил, өөрчлөлтөөс хамгийн их хамааран хувьсаж буй салбаруудын нэг юм. Алгоритм, автоматжуулалт болон өгөгдөлд суурилсан системүүд нь сэтгүүл зүйн уламжлалт хэм хэмжээ, мэргэжлийн үүрэг, ёс зүй, мэдээллийн хэрэгслийн бүтэц, зохион байгуулалт зэрэг салбарын суурь ойлголтуудыг өөрчлөн шинэчлэх хувьслын шинжтэй үзэгдэл болоод байна. Тухайлбал сэтгүүлчгүй сэтгүүл зүй буюу синтетик мэдээллийн хэрэгслүүд бий болж, мэдээллийг хурдтай боловсруулах, контент бүтээх, хэрэглэгч, хүлээн авагчдын онцлогт тохируулан олон платформд түгээх зэрэг мэргэжлийн үйл ажиллагааг хиймэл оюун дангаараа гүйцэтгэж байна.

Мэдээллийн үйлдвэрлэлд автоматжсан контент бүтээгч систем хэдийнэ нэвтэрч, мэдээлэлд анхан шатны боловсруулалт хийж, өгөгдөлд суурилсан форматын загвар бүтээх зэрэг цөөн ажил гүйцэтгэдэг байсан. Харин өнөөдөр

Two “Intelligences” Intersect: Artificial Intelligence Applications and Journalistic Adaptation. Ariunzaya.N (Ph.D.), Bayarmaa.B (Ph.D.), Mendkhuu.G (Ph.D.)

мэргэжлийн сэтгүүлчийн хийдэг баримт, эх сурвалжийг баталгаажуулах, мэдээний ач холбогдол, сэдвийг тогтоох, мэдээг үнэлэх, шийдвэр гаргах зэрэг ажил үүрэгт хиймэл оюуны системүүд нөлөөлөх болжээ.

Нөгөө талаас синтетик медиа болон AAI (Agentic Artificial Intelligence), GAI (Generative Artificial Intelligence) зэргийг ашигласан хиймэл оюунд тулгуурласан редакцын үйл ажиллагаа (мэдээний өрөөний загварууд) нь сэтгүүл зүйн ирээдүйн чиг хандлагыг тодорхойлж байна. Хиймэл оюуны нөлөө нь зөвхөн технологийн шинэлэг хэрэглээ төдий бус, харин сэтгүүл зүйн мэргэжлийн ирээдүй, нийгмийн мэдээллийн хэрэгцээ, олон нийтийн итгэлцлийн тогтолцоонд нөлөөлөх өргөн хүрээний хувьсал юм. Ийм нөхцөлд сэтгүүлчид мэргэжлийн үнэ цэн, шинж чанараа хадгалж үлдэхийн хажуугаар хиймэл оюунтай зэрэгцэн ажиллах ур чадвар, хандлагаа шинэчлэх зайлшгүй шаардлагатай болсон. Тиймээс сэтгүүлчид ажлынхаа үнэ цэнийг алдахгүйгээр хиймэл оюуны технологи бүхий орчинд дасан зохицох ямар боломж бийг судлах нь энэхүү эрдэм шинжилгээний өгүүллийн системчилсэн тойм (Systematic Literature Review)-ын зорилго болно.

Сэтгүүлчгүй сэтгүүл зүй ба уламжлалт мэдээллийн хэрэгсэл

2014 оны гуравдугаар сард “Лос Анжелес Таймс” сонины Quakebot алгоритм Калифорни мужийн газар хөдлөлтийн мэдээллийг бэлтгэн хүргэснээс хойш (Ufarte-Ruiz, 2023) AI технологийг олон улсын тэргүүлэх хэвлэл мэдээллийн байгууллагууд ашиглаж эхэлсэн. Үүнээс хойш медиагийн мэдээ үйлдвэрлэлийн үйл явц, сэтгүүлчийн өдөр тутмын ажил үүрэг тасралтгүй хувьсан өөрчлөгдсөөр байна. 2022 оны 11 дүгээр сард “OpenAI” компани GAI (Generative Artificial Intelligence) технологи болох ChatGPT-ийг танилцуулснаар мэдээллийн автоматжуулалт дараагийн шатанд гарсан юм.

Сэтгүүл зүйн салбарын үйл ажиллагаанд хиймэл оюун, тэр дундаа AAI болон GAI нэвтэрснээр синтетик (Maria-Jose Ufarte-Ruiz, 2023) мэдээллийн хэрэгслүүд бий болоод байна. “Сэтгүүлчгүй сэтгүүл зүй” (Crusafon, 2022) гэгдэж байгаа мэдээллийн хэрэгслүүдэд Испанийн “Intar Radio”, Австралийн “NewsGPT” (López, 2025), Японы “JX Press Corp”, Английн “Reuters News Tracer”, Францын “News Rebuplic” болон Испанийн “Vindere” (Maria-Jose Ufarte-Ruiz, 2023) зэрэг медиа багтаж байна. Дээрх мэдээллийн хэрэгслүүд LLM-д (Large Language Model) суурилсан AAI болон GAI технологиор контентын агуулгыг цуглуулах, боловсруулах, баталгаажуулах, түгээх үйл ажиллагааг ямар ч сэтгүүлчийн оролцоогүйгээр явуулж байна. Салбарын зарим судлаачид “Сэтгүүлч мэргэжлийн ирээдүйг AAI болон GAI хэрэгслүүд болох Midjourney, ChatGPT, Bard, Dall-E, Stable diffusion, Resemble AI зэрэг хүний бүтээлч үйлдлийг дуурайж, суралцаж,

шийдвэр гаргаж, шинэ контент бүтээх чадамжтай (Hannes Cools, 2024) хиймэл оюун тодорхойлно” гэж үзсэн.

Хиймэл оюун зөвхөн синтетик медиа, дижитал нэгдсэн платформуудын хэрэглээ бус, уламжлалт хэвлэл мэдээллийн байгууллагуудын ажлын салшгүй хэсэг болсон. Радио, телевиз, сонин зэрэг уламжлалт мэдээллийн хэрэгслүүд мэдээллийн үйлдвэрлэлдээ хиймэл оюуныг өргөнөөр нэвтрүүлж байна (Ryan J. Thomas, 2023). Контент үйлдвэрлэлийн зардлаа бууруулах, мэдээллийн эргэлтийн хурдтай хөл нийлүүлэх, мэдээний эх загвар гаргах, өгөгдөл боловсруулах, контентыг олон платформд хөрвүүлэх, хэрэглэгчийн зан төлөвт суурилсан түгээлт хийх зэргээр GAI болон автоматжуулалтын системийг тогтмол ашиглах болсон. Тухайлбал Италийн өдөр тутмын консерватив хэвлэл болох “Ил Фоглио” ямар ч сэтгүүлчийн оролцоогүй зөвхөн хиймэл оюунаар бүтээсэн анхны өдөр тутмын сониныг 2025 оны гуравдугаар сард гаргасан (Guardian, 2025). Мөн “Thomson Reuters Foundation” 2024 онд “AI эрин үеийн сэтгүүл зүй: TRF ойлголт, судалгаа”-г дэлхийн 70 гаруй улсын 200 орчим сэтгүүлчийн хүрээнд хийжээ. Судалгаанаас харахад нийт сэтгүүлчдийн 80-аас дээш хувь нь GAI-ийг редакцдаа ашигладаг, 52.4 хувь нь AI тэдний ажилд хүчтэй нөлөөлж байна гэж үзжээ. Мөн судалгаанд хамрагдсан 10 сэтгүүлч тутмын найм нь редакцад хиймэл оюуныг хэрхэн ашиглах талаар тогтсон бодлого байхгүйг дурджээ (Foundation, 2024). Ийнхүү уламжлалт мэдээллийн хэрэгслүүд хиймэл оюуны технологийг идэвхтэйгээр нэвтрүүлж байгаа нь хэвлэл мэдээллийн салбар бүхэлдээ шинэчлэгдэж, мэргэжлийн үйл ажиллагаа, редакцын зохион байгуулалт өөрчлөгдөж буйг харуулж байна.

GAI түүчээ юу, түгшүүр үү?

Сэтгүүл зүйн салбарын хиймэл оюуны идэшүүлэлт (cultivation) нь олон талт үзэгдэл юм. Нэг талаас хиймэл оюунд суурилсан системүүд мэдээлэл боловсруулах болон контент үйлдвэрлэх үйл явцын хурд, бүтээмж, нарийвчлалыг мэдэгдэхүйц нэмж, сэтгүүлчийн өдөр тутмын, хэвшсэн ажилд зарцуулах цаг хугацааг хэмнэж, мэргэжлийн практикийг шинэчилсэн. Нөгөө талаас хиймэл оюуны технологи сэтгүүлч мэргэжлийн бие даасан байдал, эрх мэдэл, редакцын хяналтын механизм, мэдээллийн үнэн зөв байдал, ёс зүйн зарчмуудад тодорхой эрсдэл учруулж болзошгүй юм. Түүнчлэн algorithmic blindness буюу аливаа зүйлийн цаад утга, нийгмийн нарийн асуудлыг мэдрэхгүй, training data bias буюу хиймэл оюуныг сургасан өгөгдлөөс шууд хамааралтай, эх сурвалж нь ил тод бус зэрэг хүчин зүйлс нь мэргэжлийн хил хязгаар, мэдээллийн экосистемийн тогтвортой байдалд нөлөөлөх магадлалтай. Дэмийрэл буюу hallucination нь хиймэл оюуны хэрэглээнд хамгийн ноцтой эрсдэл болж байгаа юм. Бодит бус мэдээллийг баримт болгон эргэлзэхгүйгээр ашиглах үзэгдлийг хиймэл

оюуны дэмийрэл гэдэг.

Мэдээллийн үйлдвэрлэлд хиймэл оюуны технологийг ашиглах нь мэдээллийн хэрэгсэлд хэвшсэн ажлыг автоматжуулж, хүний хөдөлмөрийн өртгийг бууруулах замаар зардлаа хэмнэх, хурдан, тасралтгүй үйл ажиллагаа явуулах, хүртээмж нэмэгдүүлэх зэрэг үр нөлөөтэй. Харин автоматжсан контент үйлдвэрлэл өсөхийн хэрээр сэтгүүлчийн ажлын үнэ цэн буурах, редакцын бүтцээс шахагдах эрсдэл бий (Sangyon Oh, 2024).

Уламжлалт сэтгүүл зүйн үед нийгмийн үзэгдэл, үйл явдлыг задлан шинжлэх, өгөгдөл, баримтад дүн шинжилгээ хийх, баримтыг баталгаажуулах, олон ургальч үзлээр асуудалд хандах, олон нийтийн тусын тулд хариуцлагатай мэдээлэх, ёс зүйн хэм хэмжээг баримтлах зэрэг мэргэжлийн үйл ажиллагаанд тулгуурлан сэтгүүлч “мэргэжлийн хүрээ”-г тогтоож, хамгаалсаар ирсэн (Abbott A. , 1988). Өнөөдөр ч хиймэл оюун сэтгүүл зүйн мэдээллийн чанарын үндсэн элементүүд болох ёс зүйн шийдвэр, нийгмийн хариуцлага, сэтгэл хөдлөлийг ойлгох чадвар, нийгмийн үзэгдэл, үйл явдлыг нарийн тайлбарлах талаар дутмаг (Ryan J. Thomas T. J.). Гэсэн хэдий ч, их өгөгдлийг хурдан боловсруулж, олон төрлийн контент бүтээх, эх сурвалжийг баталгаажуулах, хүлээн авагч, хэрэглэгч нэг бүрийн сонирхолд нийцсэн мэдээлэл санал болгох, түгээх зэргээр хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүтээмжийг нэмэгдүүлж байна. Тиймээс GAI нь зүгээр нэг технологийн шинэчлэл бус, харин сэтгүүлчдийг өөрсдийн мэргэжлийн хил хязгаараа шинээр тогтоох, үнэ цэнээ дахин тодорхойлох, “сэтгүүл зүй яагаад хүний удирдлагатай мэргэжил хэвээр үлдэх ёстой вэ?” гэсэн асуултад хариулах шаардлагатай болов.

Generative Artificial Intelligence (GAI) нь өгөгдөлд суурилан бичвэр, дуу, дүрс зэрэг контентыг үүсгэх чадвартай алгоритмын системийг хэлнэ. Энэ төрлийн хиймэл оюун нь их хэмжээний өгөгдлөөс зүй тогтол, хэлбэр, хандлагыг суралцан, статистик магадлалд тулгуурлан шинэ контент үүсгэдэг. Сэтгүүл зүйн салбарын GAI нь мэдээлэл үйлдвэрлэлийн хурд, хэмжээг нэмэгдүүлж, форматын олон талт байдлыг өргөжүүлж байгаа. Тийм хэдий ч GAI нь мэдээний үнэ цэнийг мэдрэх, үзэгдэл, үйл явдлын нийгмийн ач холбогдлыг тунгаах чадваргүй тул “human-oversight” буюу мэргэжлийн хүний хяналт зайлшгүй шаардлагатай хэвээр байна.

Agentic Artificial Intelligence (AAI) нь контент үүсгэх төдийгээс давж, тодорхой зорилгын хүрээнд төлөвлөх, шийдвэр гаргах, дараалсан үйлдлүүдийг бие даан гүйцэтгэх чадвартай системийг илэрхийлнэ. Онолын хувьд AAI нь “даалгавар гүйцэтгэгч агент” хэлбэрээр тодорхойлогдож, өгөгдөл цуглуулах, дүн шинжилгээ хийх, стратеги боловсруулах, үр дүнг үнэлэх зэрэг олон шаттай үйл явцыг өөрөө удирдах боломжтой. Сэтгүүл зүйн хүрээнд AAI-ийг мэдээний сэдэв олох, эх сурвалжийг урьдчилан

судлах хийх, контентын хувилбаруудыг төлөвлөх зэргээр редакцын үйл ажиллагаа, бүтцийг өөрчлөх чадавхтай гэж үнэлж байна. Иймээс ААI нь сэтгүүлч мэргэжлийн үнэ цэн, эрх мэдэл, хил хязгаар болон хариуцлагын хуваарилалтын талаар илүү гүнзгий онолын асуулт тавихад хүргэсэн технологийн дэвшил хэмээн үздэг.

Сэтгүүл зүйн салбарын хиймэл оюуны хэрэглээтэй зэрэгцэн хүн-сэтгүүлч (human-journalist), хүн төвт (human-centric) гэсэн нэр томъёо хиймэл орчин үеийн сэтгүүл зүйн үйл ажиллагаанд нэвтэрсэн. Угаас сэтгүүл зүй бол хүн төвт үйл ажиллагаа. Орчин үеийн дата, алгоритм, автоматжуулалт, GAI-д суурилсан системүүд хүний амьдралын бүхий л хүрээнд нэвт шингэж, нийгмийн харилцаа, хөдөлмөрийн зах зээл, боловсрол, бизнес, соёл, засаглал, мэдээлэл харилцааны орчныг үндсээр нь өөрчилж, хүний бус хиймэл оюуны эрин үеийг авчирсан. Технологийн энэ эрин үед хүн-сэтгүүлчийн хүн төвт үйл ажиллагаа улам үнэ цэнтэй болж байгааг салбарын судлаачид онцолсон байна. Судлаачдын бүтээлд сэтгүүл зүйн салбарт GAI-ийг хэрхэн ашиглах тухай удирдамж, GAI literacy буюу GAI-ийн боловсролын талаар дурдах нь нийтлэг байв.

Хиймэл оюуны оролцоотой мэдээллийн үйлдвэрлэлд human-oversight буюу хүний хяналт гэсэн нэр томъёог өргөн хэрэглэх болсон. Мэдээлэл цуглуулахаас түгээх хүртэлх бүхий л мэргэжлийн үйл ажиллагааг хиймэл оюун бүтээх чадамжтай болсон. Ийм нөхцөлд хиймэл оюуны үйлдвэрлэсэн мэдээллийн бүтээгдэхүүнд мэргэжлийн хүн хяналт тавьж ажиллах шаардлагатайг эрдэм шинжилгээний ажлуудад дурдсан байна.

Онолын үндэслэл

Сэтгүүл зүйн салбарын хиймэл оюуны хэрэглээг судлахдаа diffusion of innovation буюу инновацын тархалтын онолыг түгээмэл ашиглаж байна. Уг онол нь инновац ба шинэ технологи нийгэмд хэрхэн тархдагийг тайлбарладаг. Эверетт Рожерс инновац тархахад дөрвөн гол элемент шаардлагатай гэж үзсэн. Эдгээр нь инновац, харилцааны суваг, цаг хугацаа, олон нийт юм.

Редакцын хиймэл оюуны хэрэглээ, сэтгүүлч AI-ийн орчинд дасан зохицох тухай талаарх судалгааны ажлуудаас харахад “sociology of profession” буюу мэргэжлийн социологийн онолын хүрээнд сэтгүүлч мэргэжлийн харьяалал, эрх мэдлийн хүрээ, мэргэжил доторх өрсөлдөөн, болон энгийнших, эмзэгших (Abbott, 1988) байдал талаас нь судлах хандлага түгээмэл байна. Мөн аливаа мэргэжлийн эрх мэдлийн тогтвортой байдал хөндөгдөх үед тухайн мэргэжлийн үйл ажиллагааны хил хязгаарыг тогтооход чиглэдэг нийгмийн хэлэлцүүлгийн үйл явц болох (boundary work)-ийн (Sangyoon Oh, 2024) хүрээнд судалж байна. Boundary work нийгмийн хэлэлцүүлэг

нь “өрсөлдөгчид”-өөс өөрсдийгөө ялган харуулахын тулд жинхэнэ болон жинхэнэ бус мэргэжлийн мэдлэгийн заагийг гаргаж, аргумент дэвшүүлдэг. Өөрөөр хэлбэл, сэтгүүлчид технологийн шинэчлэл, тэр дундаа АAI болон GAI-ийг хэрэглэхдээ мэргэжлийн эрх мэдлээ хадгалах, хил хязгаараа тогтоох хэрэгцээ, шаардлага зайлшгүй бий болсныг сүүлийн үеийн судалгаануудаас харж болно.

Сэтгүүл зүй болон технологийн уялдаа холбоо, хэрэглээний судалгаанууд харьцангуй богино хугацаанд хуримтлагдаж байгаа ч судлаачдын анхаарлыг ихээхэн татаж олон талаас нь судалж байна. Гэсэн ч GAI-ийн мэргэжлийн баталгаажуулалтын асуудал, ажлын хил хязгаарын ажил (boundary work) болон ёс зүйн хариуцлагыг хамарсан судалгаа хомс байна. Компьютерчлагдсан сэтгүүл зүй гэдэг нь AI болон GAI-ийг багтаасан өргөн ойлголт бөгөөд мэдээ цуглуулах, боловсруулах, баталгаажуулах, түгээх гэсэн сэтгүүлчийн үйл ажиллагааны гинжин хэлхээний бүх түвшинд алгоритмыг ашиглахыг хэлнэ (Н. Kuls, 2022). 2022 оны 11-р сарын 30-нд ChatGPT нээлтээ хийснийхээ дараа таван хоногт 1 сая, хоёр сараас хэтрэхгүй хугацаанд 100 сая хэрэглэгч татсан нь GAI-ийн мэдээлэлд үзүүлэх нөлөөллийг илтгэж буй. Өдгөө мэдээлэл цуглуулахад “Вашингтон Пост”-ын “Lead Locator” хэрэгсэл, боловсруулахад “BBC”-ийн “Juice” NLP систем, “Нью Йорк Таймс”-ын “Echo”-г, харин баталгаажуулахад Бельгийн “Factrank” болон Нэгдсэн Вант Улсын “Full Facts” зэрэг алгоритмтай хэрэгслүүдийг, мөн “Chartbeat”, “Smartocto” зэрэг мэдээ түгээх, зохицуулах хэрэгслүүдийг ашиглаж байна.

Абботтын мэргэжлийн социологийн онолын хүрээнд авч үзвэл мэргэжил бүр тодорхой асуудлыг шийдвэрлэх онцгой мэдлэг, чадварын jurisdiction буюу “харьяалал” -тай байдаг. Сэтгүүл зүй нь хатуу лицензийн тогтолцоогүй ч нийгмийн өмнө чухал үүрэг хүлээдэг, ёс зүйн хэм хэмжээтэй, практикаар эзэмшдэг мэргэжил гэж тодорхойлдог (Deuze, 2005). Ажлын хил хязгаар (boundary work) нь аливаа мэргэжлийн бүлэг гаднаас ирж буй бэрхшээлийн эсрэг өөрсдийн мэргэжлийн хил хязгаарыг тодорхойлж, хамгаалдаг нийгмийн практикийг тайлбарладаг (Carlson, 2015).

Сэтгүүл зүйн ажлыг гадны хүмүүс болон технологиор орлох боломжтой байх нь энэхүү мэргэжлийн эмзэг тал болж байна. Онлайн мэдээ бэлтгэгчид, иргэний блоггерууд болон GAI систем нь сэтгүүлчийн уламжлалт “харьяалал”-д нэвтэрч байгаа нь мэргэжлийн баталгаажуулалтад учирч буй шинэ дарамт юм.

GAI нь мэдээний өрөөний ёс зүйн асуудлуудад дор хаяж гурван замаар нөлөөлж буй. Нэгд, алгоритмын өрөөсгөл байдал буюу algorithmic bias нь мэдээллийн олон ургальч, тэнцвэртэй байдлыг алдагдуулах, хоёрт, GAI-аар бүтээгдсэн контентын нарийвчлалгүй, найдваргүй байдал буюу дэмийрэл

(hallucination), гуравт, хянан засах үйл ажиллагааны ил тод байдал болон хүний хяналтын асуудал (Küls, 2024) юм. Марк Дьюзийн тэмдэглэснээр сэтгүүлчийн ёс зүй нь мэргэжлийн үндсэн зарчмуудыг хамгаалах хөтөч болж, GAI-ийн хөгжлийн энэ үед улам бүр чухал болжээ.

Судалгааны арга зүй

Энэхүү өгүүлэл нь эрдэм шинжилгээний WOS сангаас “journalism and artificial intelligence” гэсэн түлхүүр үгээр хайхад гарч ирсэн өгүүлүүдээс зохих арга зүйн дагуу сонгосон судалгааны ажлуудад шинжилгээ хийсэн системчилсэн тойм (Systematic Literature Review) юм. Уг судалгаа нь,

Мэдээний өрөөнд GAI хэрэгслийн хэрэглээний практикийг тодорхойлох,

Сэтгүүлчид GAI-ийн хөгжлийн үед өөрсдийн мэргэжлийн байр суурийг хэрхэн тодорхойлж хамгаалж байгааг судлах,

GAI-ийн хариуцлагатай хэрэглээ, хэрэглээний ёс зүй болон институцын нөхцөл шаардлагыг тодорхойлох зорилготой юм.

Ингэхдээ судалгаанд хамруулсан эрдэм шинжилгээний өгүүллээ дараах байдлаар сонгов.

Хүснэгт 1. Судалгааны эх хэрэглэгдэхүүнийг сонгосон PRISMA.



Судалгааны эх хэрэглэгдэхүүнээр дараах өгүүлүүдийг сонгосон.

Хүснэгт 2. WoS сан дахь тухайлсан сэдвийн талаарх хамгийн олон эшлэгдсэн өгүүлүүд.

№	Гарчиг	Зохиогч/ он	Эшлэгдсэн тоо
N1	Мэдээний өрөөний GAI-ийн хэрэглээ: Эрдэл болон боломжийн талаарх сэтгүүлчдийн ойлголт	Hannes Cools, Nicholas Diakopoulos. 2024.	59
N2	AI-тай үеийн сэтгүүл зүйн итгэлцэл	Andreas L Opdahl, Bjornar Tessem etc. 2023.	40
N3	Сэтгүүл зүй дэх AI: Шинэ технологи ChatGPT-гийн хэрэглээ ба эрсдлүүд	Beatriz Gutierrez-Caneda, Jorge Vazquez-Herrero, Xose Lopez-Garcia. 2023.	36
N4	Гарчгийн ард байгаа алгоритмыг эргэж харах нь: Сэтгүүлчид GAI-тай хийж байгаа мэргэжлийн өрсөлдөөнд ямар хариу өгч байна вэ?	Arjen Van Dalen. 2024.	28
N5	Хүний мэдрэмжийн өчүүхэн ул мөр: AI-ийн үед энгийн сэтгүүлчид өөрсдийнхөө ажлыг хэрхэн дахин тодорхойлж байна вэ?	Lyng Asbjorn, Arjen Van Dalen, Morten Skovsgaard. 2024.	10
N6	Сэтгүүлч яаж харагдах вэ? Сэтгүүлчийн үүргийг AI-аар харахуй	Ryan J. Thomas, T.J.Thomson.2023.	10

Үр дүн

Сэтгүүл зүйн салбар дахь хиймэл оюуны хэрэглээний талаарх дурдсан судалгаануудаас харахад GAI-ийг хэрэглээ нь салбарын хувьд туршилтын шатанд байна. Сэтгүүлчид GAI-ийг голчлон мэдээ цуглуулах, боловсруулах болон түгээх үйл явцад ашиглаж байна. WOS-д олон эшлэгдсэн дурдсан судалгаануудыг хийх үед ChatGPT, Bing, BingChat зэрэг GAI-аас ChatGPT-ийг хамгийн өргөн хэрэглэж байв. Сэтгүүлчдийн олонх нь мэдээ, мэдээллийн эх сурвалжийг баталгаажуулах болон баримт шалгах ажилд GAI-ийг хэрэглэх боломжгүй гэж үзсэн. Одоогоор сэтгүүлчид эрэн сурвалжлах сэтгүүл зүй, улс төрийн анализ, эх сурвалжаас мэдээлэл авч бичих зэрэг сэтгүүлчийн ажлын “цөм” үйлдлүүдэд GAI хэрэглэдэггүй. Харин спортын

болон санхүүгийн тодорхой мэдээлэлд GAI-ийг ашиглах нь түгээмэл байна.

Бидний системчилсэн задлан шинжилгээнээс харахад сэтгүүлчид GAI-ийн гол боломжийг доорх байдлаар тодорхойлжээ. Нэгд, өдөр тутмын механик, давтамжтай ажлуудыг автоматжуулснаар сэтгүүлчид нийгэм, улс төрийн даацтай бүтээл туурвих, дүн шинжилгээ хийх, бүтээлч сэтгэлгээ, нийгмийн ач холбогдолтой сэдвүүдэд анхаарлаа хандуулах цаг, завтай болно. Хоёрт, хувь хүнд зориулсан контент бүтээх, олон платформд зориулан форматлах боломж өссөнөөр хүртээмж үлэмж хэмжээгээр нэмэгдэнэ. Гуравт, өргөн цар хүрээтэй хүлээн авагчдад хэлний саад тотгоргүй хүрэх боломж гарна. Тухайлбал Испани хэлэнд шууд орчуулга хийх гэх мэт. Эрэн сурвалжлах сэтгүүлчид GAI-д онцгой зэрэгээр хандаж, баримт бичиг боловсруулах, том хэмжээний датаг шинжлэх, дэлгэрэнгүй мэдээлэлд хурдан хандах боломжийг, хууль бус болон нийгмийн хэм хэмжээг зөрчсөн зүйлийг илрүүлэхэд тусалж байгааг дурьдсан байна. “Автоматын хамгийн сайн чадваруудтай хүний хамгийн сайн чанар нэгдвэл хэн хэнийгээ орлохгүй харин уншигч, олон нийтэд ухаалаг хурднаар үйлчилж чадах кибернетик мэдээний өрөөг бий болгож болно” (Chow, 2022).

Судалгаануудад нийтлэг тодорхойлогдсон бэрхшээлүүдийг дараах байдлаар авч үзлээ. Үүнд:

Дэмийрэл hallucination буюу нарийвчлалгүй мэдээлэл. GAI нь хуурамчаар эш татаж буруу баримт гаргах боломжтой бөгөөд энэ нь мэдээний найдвартай байдалд асар хортой.

Алгоритмын өрөөсгөл байдал. GAI нь сургагдсан өгөгдлөөсөө хамаарч хэвшмэл ойлголтыг дахин үйлдвэрлэх, нэг талыг барих боломжтой. Энэ нь нийтлэл, нэвтрүүлгийн олон ургальч, тэнцвэртэй байх зармийг алдагдуулах эрсдэлтэй.

Сэтгүүлчийн бие даасан байдал болон ур чадварын доройтол. GAI-д хэт найдснаар шүүмжлэлт сэтгэлгээ болон гүн шинжилгээний чадвар суларч болзошгүй,

Мэргэжлийн онцгой дуу хоолой алдагдах. GAI-аар сэтгүүлчийн хувийн найруулга, өнцөг, өнгө аяс, байр суурийг орлох нь тэдний мэргэжлийн ялгаатай байдлыг устгана,

Ажлын утга учир болон мэргэжлийн нэр хүнд алдагдах. GAI нь сэтгүүлчид бахархалтайгаар хийдэг бүтээлч ажлуудыг орлоход мэргэжлийн сэтгэл ханамж, ур чадварын үнэлэмж буурна.

Ван Даленийн судалгаанаас харахад мэтасэтгүүл зүйн дискурст ChatGPT нь тоглоомын дүрмийг өөрчилдөг хүч буюу game changer гэсэн бол Асбьёрн нарын судалгаанд өдөр тутам мэдээллийн 75 хувь нь GAI-

аар бүрэн автоматжуулагдах боломжтой гэж үзсэн сэтгүүлчид мэргэжлээ алдах айдастай байгааг харуулж байна. Судалгааны ажлуудын нийтлэг дүгнэлтийн хамгийн чухал хэсэг нь сэтгүүлчид GAI-аас ялгарахын тулд “хүний мөн чанар” буюу human quality-ыг гол шалгуур болгон дэвшүүлж байгаа явдал юм.

Судалгааны оролцогчид дор дурьдсан хүчин зүйлсийг GAI орлож чадахгүй сэтгүүлчийн “цөм” чадвар гэж тодорхойлсон байна.

Эмпати болон хүний харилцаа. Эх сурвалжтай биеэр уулзах, хүнтэй харилцах, нөхцөл байдалд тааруулан мэдрэмжтэй хандах чадвар нь GAI-д байдаггүй,

Шүүмжлэлт болон эрэн сурвалжлах сэтгэлгээ. Нуугдсан мэдээллийг ил болгох, эрх мэдэлтнүүдийг шалгах, дотоод мэдрэмжинд тулгуурлан нийгмийн аливаа үзэгдэл, үйл явдлын үнэ цэнийг таних,

Бүтээлч, өвөрмөц илэрхийлэл. Хувийн найруулга, өнгө аяс, сэтгэл хөдлөлийн өнгө аяс гэхчлэн GAI нь хэлний дүрмийг дагадаг ч “амьд” илэрхийлэл хийж чадахгүй,

Ёс зүйн шийдвэр гаргах чадвар. Шүүх хурлын буруу шийдвэрээс үүдэлтэй хэлмэгдэлтийн “нулимс”, нийгмийн зөрчилдөөний нарийн ёс зүйн ньюансыг ялгаж таних нь зөвхөн хүнд байна,

Нийгмийн итгэлцэл. Олон нийттэй урт хугацааны харилцаа тогтоох, коммунитид үйлчлэх хариуцлага нь сэтгүүлчийн мэргэжлийн үндсэн шинж чанар.

Ван Даленийн судалгаанд GAI-ийн бичсэн текст “дундаж, ахлах ангийн хүүхдийн загвар”, “өнгөц түвшинд” байгаа, “хувь зан байдалгүй”, “амьгүй” гэх мэтээр дүгнэсэн нь сэтгүүлчийн уран бүтээлч мөн чанар нь GAI-д дутмаг болохыг илтгэж байна. Судлаач Bogost-ын хэлснээр ChatGPT нь итгэл үнэмшилтэй харагддаг зүйлийг бүтээж чадах ч мэргэжлийн сэтгүүлчийн нийтлэл нэвтрүүлгийн гүн агуулгатай дүйцэхгүй гэж үзжээ.

Хэлэлцүүлэг

Дээрх зургаан судалгааны нэгтгэсэн дүн шинжилгээнээс харахад GAI нь 2010-аад оны эхэн үеийн rule-based автомат сэтгүүл зүйгээс ялгарсан шинэ давалгааг бүрдүүлж байна. Тэр үеийн автоматжуулалт нь зөвхөн цаг агаар, спорт, санхүүгийн тоон мэдээллийг боловсруулах чадамжтай байсан бол GAI нь хэлний чадамжийн хувьд сэтгүүлчийн мэргэжлийн “харьяалал”-д шууд нэвтэрч байна. Абботтын онолын хүрээнд авч үзвэл сэтгүүл зүйн мэргэжлийн баталгаажуулалтын “абстракт мэдлэг” суурь биш, харьцангуй байдаг нь сэтгүүлч мэргэжлийн “эмзэг” байдлыг нэмэгдүүлж байна.

GAI нь мэдлэгийн хуримтлал бус ур чадварын дадал дээр тулгуурлан баталгааждаг сэтгүүлчийн мэргэжлийн орон зайд өрсөлдөж байна. Гэсэн хэдий ч судалгаанд оролцогчид “хүний мөн чанар”-аар тодорхойлогдох чадваруудыг буюу эмпати, шүүмжлэлт сэтгэлгээ, ёс зүйн хариуцлага, бүтээлч илэрхийлэл GAI-д дутмаг гэж тодорхойлж, мэргэжлийн шинэ хил хязгаарыг түүгээр татаж байгаа нь онцлог юм.

Асбьёрн нарын судалгаа нь мэргэжлийн түвшин болон ажлын үүргийн хувьд ялгаатай нөлөөллийг тодруулсан. Өдөр тутмын мэдээ бэлтгэдэг general assignment reporter сэтгүүлчид GAI-ийн нөлөөнд илүү өртөмтгий бол эрэн сурвалжлах сэтгүүлчид GAI-ийг ажлаа өргөжүүлэх хэрэгсэл гэж харж байна. Энэхүү ялгаатай байдал нь зөвхөн ажлаа алдах айдсаас биш, мэргэжлийн identity болон ажлын утга учир алдагдах гэсэн нарийн сэтгэл зүйн талаасаа ч илэрч байна. Судалгаануудын нийтлэг зөвлөмжийн гол нь GAI-ийг сэтгүүлчийн практикт хариуцлагатайгаар нэвтрүүлэхэд дор дурьдсан нөхцөл шаардлагатай гэж дүгнэсэн.

Нэгд, яг ямар даалгавар дээр GAI ашиглах, эсвэл ашиглахгүй вэ гэдгийг тодорхойлсон байгууллагын удирдамж (editorial guideline) гаргах.

Хоёрдугаарт, GAI хэрэглэхэд мэргэжлийн сэтгүүлчийн хяналт, зааварчилгаа зайлшгүй шаардах,

Гуравдугаарт, GAI-аар бэлтгэсэн агуулгыг ил тодоор тэмдэглэх (transparency stamp),

Дөрөвдүгээрт, сэтгүүл зүйн боловсролын байгууллагууд AI-ийн ёс зүй болон хариуцлагатай хэрэглээний талаарх агуулгыг сургалтдаа нэвтрүүлэх шаардлагатай.

Дүгнэлт

Энэхүү өгүүлэл нь GAI сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаанд тулгасан нарийн төвөгтэй сорилт, бэрхшээл болон боломжийг хэд хэдэн өөр судалгааны ажлын үр дүнд тулгуурлан харуулсан болно. Мэдээ, мэдээлэл боловсруулах үйл ажиллагаанд хэдийнэ нэвтэрсэн автоматжуулалтыг GAI дараагийн шатанд авч ирж сэтгүүлчийн мэргэжлийн “цөм” чадварт шууд нөлөө үзүүлж байна. Мэдээллийн ажилтан, сэтгүүлчид хүний мөн чанар болох эмпати, шүүмжлэлт сэтгэлгээ, бүтээлч ур чадвар, ёс зүйн хариуцлагын дагуу мэргэжлийн шинэ хил хязгаарыг тогтоожээ. GAI-ийн нөлөөлөл нь сэтгүүлч мэргэжлийн түвшин болон ажил үүргийн хуваариас хамаарч ялгаатай байна. Тухайлбал сэтгүүлчийн өдөр тутмын тогмол үйл ажиллагааг хиймэл оюун ухаанаар хийлгэх бүрэн бололцоотой ч тухайлсан сэдвийн мэргэшсэн сэтгүүлчийн ажлыг хиймэл оюун орлох боломжгүй юм. Цаашлаад AI хэрэглээний хариуцлагын талаар институцийн зохицуулалт

болон сургалтын тогтолцоо нэн шаардлагатай байгааг судалгааны дүгнэлтээс харж болно. GAI бол сэтгүүл зүйн мэргэжлийг “human-centric journalism” буюу хүн төвтэй сэтгүүл зүй болгон дахин тодорхойлох боломжийг авчирч байна. Дижиталчлал нь автоматжуулалтыг авчирч байсан бол GAI нь сэтгүүл зүйд “яагаад хүн хэрэгтэй вэ” гэдэг үндсэн асуултыг улам гүнзгийрүүлж байна. Хиймэл оюун ухаан сэтгүүлчийн дасан зохицолын дараа дараагийн судалгаанд GAI-ийн сэтгүүлчийн мэргэжлийн аз жаргал, нийгмийн нөлөөлөл болон хэвлэл мэдээллийн байгууллагын менежментийн байр суурь мөн хүлээн авагчдын хандлагыг судлах нь чухал хэвээр байна.

Ашигласан бүтээл:

- Abbott, A. (1988). *The system of professions: An essay on the division of expert labor*. University of Chicago Press.
- Asbjørn, L., Van Dalen, A., & Skovsgaard, M. (2024). *A small piece of human touch: How ordinary journalists redefine their work in the age of AI*. Journalism Studies.
- Bogost, I. (2022). *ChatGPT is dumb*. The Atlantic.
- Braun, V., & Clarke, V. (2006). *Using thematic analysis in psychology*. Qualitative Research in Psychology, 3(2), 77–101.
- Broussard, M., Diakopoulos, N., Guzman, A. L., Abebe, R., Dupagne, M., & Chuan, C.-H. (2019). *Artificial intelligence and journalism*. Journalism & Mass Communication Quarterly, 96(3), 673–695.
- Carlson, M. (2015). *The robotic reporter: Automated journalism and the redefinition of labor, compositional forms, and journalistic authority*. Digital Journalism, 3(3), 416–431.
- Carlson, M., & Lewis, S. C. (2015). *Boundaries of journalism: Professionalism, practices and participation*. Routledge.
- Chow, A. R. (2022). *The future of the news could be automated*. Time.
- Deuze, M. (2005). *What is journalism? Professional identity and ideology of journalists reconsidered*. Journalism, 6(4), 442–464.
- Deuze, M. (2015). *What journalism is (not)*. Social Media + Society, 1(1), 1–2.
- Küls, H. (2022). *Automated journalism in the newsroom: How news organizations use algorithms to produce content*. [Dissertation].
- Küls, H., & Diakopoulos, N. (2024). *Perceptions of GAI use in the newsroom: Journalists' fears and opportunities*. Journalism Practice.
- Olsen, R. K. (2022). *Automation anxiety and journalistic skill: The reskilling of journalists in the algorithmic age*. Journalism Studies.
- Ornebring, H. (2009). *The two professionalism of journalism*. In B. Zelizer (Ed.), *The changing faces of journalism*. Routledge.
- Thurman, N. (2018). *Computational journalism*. In T. P. Vos & F. Hanusch (Eds.), *The international encyclopedia of journalism studies*. Wiley.

Van Dalen, A. (2024). *Revisiting the algorithm behind the headlines: How journalists respond to professional competition from GAI*. Journalism Practice.

WAN-IFRA. (2023). *AI in the newsroom: Risks and opportunities*. World Association of News Publishers.

Summary

This study synthesizes findings from six independent studies to examine how Generative Artificial Intelligence (GAI) is reshaping professional journalism. While the intersection of journalism and technology has attracted growing scholarly attention, research remains limited in addressing GAI's implications for professional legitimacy, boundary work, and ethical accountability within newsrooms.

This article pursues three primary objectives: to identify practical applications of GAI tools in newsroom settings; to investigate how journalists define and defend their professional identity amid rapid GAI development; and to determine the ethical frameworks, responsible use standards, and institutional conditions governing GAI adoption in journalistic practice.

The findings reveal that GAI tools are increasingly integrated into newsroom workflows, yet their adoption is accompanied by significant professional tensions. Journalists actively engage in boundary work to distinguish their expertise from automated processes, asserting the irreplaceable value of human judgment, source relationships, and ethical reasoning. At the institutional level, the study identifies a gap between the pace of GAI deployment and the development of coherent editorial policies and accountability structures.

This synthesis contributes to emerging scholarly discourse on AI and journalism by highlighting the need for robust professional guidelines, transparent ethical standards, and institutional frameworks that support responsible GAI use. The study underscores that the future of journalism in the age of generative AI depends not only on technological adaptation but on the deliberate preservation of professional values and public trust.

Keywords: Generative Artificial Intelligence (GAI), AI and Journalism, Professional Journalism, Newsroom Automation, AI-Assisted Journalism, Journalistic Ethics, Ethical AI Use, Editorial Accountability, Professional Legitimacy, Boundary Work in Journalism, Journalistic Identity, Human Judgment in Journalism, Newsroom Innovation, Digital Journalism, AI Governance, Responsible AI Adoption, Media Ethics, Algorithmic Accountability, Public Trust in Media, Editorial Policy, Automated Content Production, Journalism and Technology, Human–AI Collaboration, AI Integration in Newsrooms, Institutional Frame-

works, Journalism Practice, Media Professionalism, Technological Adaptation, AI Regulation in Media, Newsroom Workflows